

АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Байгууллагын цахим хуудсаар "Шинэ номын тойм"-ын мэдээлэл болон "Нутгийн найрагч" булангаар Сүхбаатар нутгийн зохиолч, яруу найрагчдын уран бүтээлийг тогтмол сурталчилж байна.

Мөн уншигчдад зориулсан заавал унших зохиолууд, ном унших зөвлөмжүүд, номын сангийн тухай хуулийн талаар цахим хуудсаар сурталчлав.


Луй Брайлийн мэндэлсний 214 жилийн ойг тохиолдуулан аймгийн хараагүйчүүдийн холбоотой хамтран Луй Брайлийг алдаршуулах, брайль үсгийг танин мэдэх, танилцуулан сурталчлах зорилгоор брайль номын үзэсгэлэн, брайль уншлага зохион байгуулж, АХА тэмцээн зохион байгуулсан.



Хүүхдийн танхимын номыг ангилан, ялгаж хаягжуулалт хийсэн.



Халзан сумын соёлын төвийн номын санд очиж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.



Хүүхдийн ном унших орчинг цэвэр тоос шороогүй байлгах зорилгоор 21 ширхэг хос улавч оёсон.

